
Lantuun Dohio
UNITED AGAINST CHILD ABUSE & HUMAN TRAFFICKING

ЦАХИМ БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ
ба эцэг эхчүүд юуг мэдэх хэрэгтэй вэ?

NetSmartz® | A program of the NATIONAL CENTER FOR MISSING & EXPLOITED CHILDREN®

Цахим бэлгийн мөлжлөг:

Хүүхдийг нүцгэн зураг, хувийн мэдээллээр нь барьцаалан тэдгээрийг олон нийтэд дэлгэнэ хэмээн айлган сүрдүүлэх замаар нэмж зураг авах, бэлгийн харилцаанд орох, мөнгө өгөхийг шаарддаг нэгэн төрлийн мөлжлөг юм. Энэ гэмт хэрэг нь хүүхэд хувийн зургаа хэн нэгэнд илгээсэн эсвэл хүүхдийн зургийг хэн нэгэн хуурамчаар эвлүүлсэн үед гарч болно.



Хэрэгтнүүд мэдээллийг хэрхэн олж авдаг вэ?

Ихэнх тохиолдолд таньдаг хүн буюу өмнө эсвэл одоо хосын харилцаатай байгаа хүн энэхүү гэмт хэргийг үйлддэг. Мөн онлайнаар танилцсан хүн ийнхүү сүрдүүлэх тохиолдол цөөнгүй бий. Энэ тохиолдолд гэмт хэрэгтэн онлайнаар танилцсаныхаа дараахан хүүхдийн нүцгэн зургийг, эсвэл хиймэл оюун ухаан ашиглаж хуурамчаар бүтээсэн контентоо ашиглан мөнгө нэхэх байдлаар дарамталж, санхүүгийн мөлжлөг үзүүлдэг байна.

1 Танилцах

Гэмт хэрэгтнүүд ихэвчлэн **олон нийтийн сүлжээг холбоо тогтоох анхны сувгаа болгож**, тухайн хүүхдийн сонирхдог зүйлс, найзууд, сургууль, гэр бүл гэх мэт сэдвүүдийн талаар мэдээлэл цуглуулдаг. Дараагаар нь тэд нууцлалын системтэй сувгаар харилцахын тулд хүүхдэд **хоёр дох эсвэл гурав дах суваг руу шилжиж** харилцахыг санал болгодог. Үүнээс гадна, **өмнө нь хосын харилцаатай байсан,** эсвэл өмнө нь хохирогчийн хувийн зургийг хүлээн авч байсан хүмүүс энэхүү гэмт хэргийг үйлдэх магадлалтай.

2 Ятгах тактик

Сүрдүүлэгч нар мөнгө эсвэл мансууруулах бодис гэх мэт өндөр өртөгтэй зүйлээр нүцгэн зураг, бичлэгийг нь худалдаж авах, моделийн агентлагт ажилладаг мэт болж жүжиглэх, хайр дурлалын харилцаатай болохоор сонирхож байгаа мэт дүр үзүүлэх, хуурамч контент эвлүүлэх, эсвэл хувийн хаягийг нь хакердаж нүцгэн зургийг нь хулгайлах гэх мэтчилэн **төрөл бүрийн арга ашигладаг.**

3 Сүрдүүлэг


Гэмт хэрэгтэн **“зураг, бичлэгийг чинь тараана” хэмээн дарамталснаар** хохирогчийг харилцаандаа авч үлдэх, бэлгийн зан үйлийн агуулгатай контент нэмж авах, эсвэл мөнгө өгөхийг шаардаж болно. Мөн **тэд хүүхдэд эсвэл тэдний гэр бүлд бие махбодын хүчирхийлэл үйлдэнэ,** хуурамч түүх зохион амьдралыг нь сүйтгэнэ хэмээн сүрдүүлж магадгүй юм.

© This document was translated by Lantuun Dohio USA from an original document created by the National Center for Missing and Exploited Children (NCMEC). Original documents can be found at ncmec.org/netsmartz/resources. Any grammatical, technical issues, or deviations from the source material are the sole responsibility of Lantuun Dohio USA.

Та юу хийж чадах вэ?

1 Оролцох

- Хүүхдийнхээ олон нийтийн сүлжээн дэх амьдралд нь **идэвхтэй оролцох.**
- Цахимаар хэнтэй харилцаж буйг нь **үе үе шалгаж** хэвших.
- Цахим болон бодит ертөнцөд гаргаж буй зан авир болоод дадал зуршилд нь **шаардлага тавих.**





2 Бэлгийн харилцаа болон үерхлийн талаар нээлттэй ярилцах

Бэлгийн харилцаа болон үерхлийн талаар танай гэр бүлийнхэн ямар байр суурьтай байдаг бөгөөд ямар зарчим баримталдаг тухай тогтмол ярилцаж байгаарай. Эрүүл харилцаа ямар шинж тэмдэгтэй байдаг буюу нэг нэгнийхээ хил хязгаарыг хүндэтгэх болон зөвшөөрөл авч байх талаар мөн хэлж өгөөрэй. Хэн нэгэнд шахалт үзүүлэх, өөрөө шахалтад орох эсвэл аюултай бэлгийн зан үйлдэл хийх нь **зөв зүйл биш.** Хүүхдээдээ **бэлгийн харилцааны талаарх мессежийг хэнээс ч ирсэн бай цааш дамжуулж огт болохгүйг** анхааруулж, аливаа зураг дүрсийг цааш тараахгүй байх нь тэдгээрийг аюултай хүний гарт орохоос сэргийлж байдгийг ойлгуулаарай.

3 Хүүхдээ зоригжуулах

- Хүүхдээдээ тусламж авч болох эх сурвалжуудын талаар хэлж өгөөрэй. Жишээлбэл, TakeItDown.NCMEC.org болон CyberTipline.org. гэх мэт.
- Хүүхдээдээ хэрхэн **сэжигтэй хүний талаар гомдол мэдүүлэх вэ** гэдгийг зааж өгөөрэй.
- Бэлгийн мөлжлөг бол гэмт хэрэг гэдгийг хүүхдээдээ **сануулж, хүүхдийн тань буруу биш** бөгөөд та үргэлж тэдэнд туслахад бэлэн байгаагаа илэрхийлээрэй.



© This document was translated by Lantuun Dohio USA from an original document created by the National Center for Missing and Exploited Children (NCMEC). Original documents can be found at ncmec.org/netsmartz/resources. Any grammatical, technical issues, or deviations from the source material are the sole responsibility of Lantuun Dohio USA.